| Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | |
|---|---|
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. | |
| **Тайлагнах хугацаа** | 2025 оны 1-р сарын 01-нээс 2025 оны 6-р сарын 30-ны өдөр |
| **Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар** | "ЭМ ЖИ ЭЛ АКУА" ХК, 000274041, MSE: MGLA, 77045555 |
| **Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр** | Монголын хөрөнгийн бирж ХК |
| **Бизнесийн үйл ажиллагааны салбар** | Хүнсний үйлдвэрлэл, Шингэн хүнсний үйлдвэрлэл |
| **Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг** | 327,555,616 (Гурван зуун хорин долоон сая, таван зуун тавин таван мянга зургаан зуун арван зургаа) ширхэг |
| **Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр** | Бэлтгэсэн: Г.Намхайдорж (ТУЗ НБД)<br>Хянасан: С.Алтантуяа (Гүйцэтгэх захирал) |

| | | |
|---|---|---|
| 1. | Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ | |
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | **Тайланг хавсаргав.** |
| | Орлогын тайлан | **Тайланг хавсаргав.** |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | **Тайланг хавсаргав.** |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | **Тайланг хавсаргав.** |
| 2. | **Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт** | |
| | Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын дүгнэлтийг хавсаргана. | |
| 3. | **Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт** | |

| | | |
|---|---|---|
| 3.1 | **Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/** | Санхүүгийн үзүүлэлтүүд<br>**Ашигт ажиллагаа** |
| 3.2 | **Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт** | Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ 1%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 1%<br><br>**Хөрөнгөнд эзлэх хувь**<br>Өөрийн хөрөнгө/нийт хөрөнгө 90%<br>Өр төлбөр/ Нийт хөрөнгө 19%<br><br>**Хөрвөх чадварын харьцаа**<br>Эргэлтийн харьцаа 2.9%<br>Төлбөрийн хөрвөх чадварын харьцаа 2.3%<br>Бэлэн мөнгөөрх төлбөрийн чадварын харьцаа 1.85% |
| 3.3 | **Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл** | Компани 2025 оны эхний хагас жилд маркетинг борлуулалтын харилцагч болон хэрэглэгчийн 3 хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.<br>5 болон 6-р сард компанийн төлөвлөгөө өндөр борлуулалт ихтэй сар тул харилцагчийн агуулах, зай талбайг бүтээгдэхүүний нөөц бүрдэлтээр хангаж ажилласан. Энэ нь өмнөх мөн оны үетэй харьцуулсан алдагдсан борлуулалтыг 10%-р өсгөж чадсан. |
| 3.4 | **Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого** | Санхүүгийн байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй |
| 4. | **Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/** | |
| | 2025.03.19 өдөр ТУЗ-ийн Т/39 тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан. Уг хэлцлээр Эм жи эл аука ХК-ийн охин компани Ти эм эл акуа ХХК Ньюгор ХХК-тэй Өмнөговь аймагт байгуулах цэвэр усны үйлдвэр барих ажлын гэрээг зөвшөөрсөн. | |
| 5. | **Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл** | |
| | Эм Жи Эл Акуа ХК нь 2024 оны 5-р сарын 31-ний өдөр IPO-оор татан төвлөрүүлсэн 15,234,676,684 төгрөгийг өөрийн банкны дансанд хүлээн авсан болно.<br>IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,116,812,809 төгрөгийг түүхий эд, материал (ТЭМ) худалдан авахад зарцуулсан бөгөөд уг зардлыг 2024 онд бүрэн санхүүжүүлж дуусгасан.<br>2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам худалдан авахад 4,500,000,000 төгрөг, трансформатор худалдан авахад 550,000,000 төгрөг тус тус зарцуулсан. 2025 оны 5 дугаар сарын 29-ний байдлаар орон нутгийн үйлдвэрийн төсөлд IPO-оос татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6,067,863,875 төгрөг, компанийн өөрийн орлогоос 70,138,125 төгрөг тус тус зарцуулсан байна. | |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| | |
|---|---|
| Овог, нэр: С.Алтантуяа<br><br>Албан тушаал: “Эм Жи Эл Акуа ” ХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг:<br><br>*(Тамга/тэмдэг)* | Овог, нэр: Д.Бат-Ирээдүй<br><br>Албан тушаал: “Эм Жи Эл Акуа ХК”-ийн Ерөнхий нягтлан бодогч<br><br>Гарын үсэг:<br><br>*(Тамга/тэмдэг)* |

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Галхүү Нансалдорж

Албан тушаал: ТУЗ НБД

Гарын үсэг:

MGL aqua

ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК

# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



# Бидний тухай

1 “ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ний тухай

2 Үйл ажиллагааны хураангуй

3 Санхүүгийн үзүүлэлт

4 Байгаль орчин, Нийгэм, Засаглал




# НЭГ.
# ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК-НИЙ ТУХАЙ

# Бидний тухай

## Алсын хараа

Байгалийн цэнхэр алтыг дэлхийн дэвшилтэт технологи, хүнсний үйлдвэрлэлийн олон улсын стандартаар олборлон, тогтвортой хөгжлийн бодлогыг баримтлан үйлдвэрлэж Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна.

## Эрхэм зорилго

Экологийн тэнцвэрийг хамгаалан өвлүүлж, бүс нутагтаа хариуцлагатайгаар бизнесээр тэргүүлнэ

## Үнэт зүйл

Чанартай бүтээгдэхүүн
Чадварлаг ажилтан
Тогтвортой харилцагч
Үнэнч хэрэглэгч



# ХОЁР.
# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

# ТУЗ-ын үйл ажиллагаа

Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 онд дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Үүнд:

## АУДИТ ЭРСДЛИЙН ХОРОО



**Ч. АНХБАЯР**
Аудит эрсдлийн хорооны дарга

**Г. МӨНХ-ЭРДЭНЭ**
Аудит эрсдлийн хорооны гишүүн

**О. САНСАР**
Аудит эрсдлийн хорооны гишүүн

## НЭР ДЭВШҮҮЛЭХ БОЛОН ЦАЛИН УРАМШУУЛАЛЫН ХОРОО



**С. САНАСЭР**
Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга

**Ч. АНХБАЯР**
Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн

**О. САНСАР**
Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн

## СТРАТЕГИ БИЗНЕС ХӨГЖЛИЙН ХОРОО



**М. ДӨЛГӨӨН**
Стратеги бизнес хөгжлийн хорооны дарга

**Х. ТЭГШЭЭ**
Стратеги бизнес хөгжлийн хорооны гишүүн

**С. САНАСЭР**
Стратеги бизнес хөгжлийн хорооны гишүүн

**С. АЛТАНТУЯА**
Стратеги бизнес хөгжлийн хорооны гишүүн

**Д. БАСАНДОРЖ**
Стратеги бизнес хөгжлийн хорооны гишүүн

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ХАРИЛЦААНЫ ХОРОО



**Г. МӨНХ-ЭРДЭНЭ**
Хөрөнгө оруулагчдын харилцааны хорооны дарга

**Д. БАСАНДОРЖ**
Хөрөнгө оруулагчдын харилцааны хорооны гишүүн

**М. ДӨЛГӨӨН**
Хөрөнгө оруулагчдын харилцааны хорооны гишүүн

# ТУЗ 2025 оны хагас жилийн тайлан

- Эм жи эл акуа ХК-ийн ТУЗ 2025 оны эхний хагас жилд нийт 9 удаа хуралдсан. Тайлант хугацаант 1 сонирхлын зөрчилтэй хэлцэл батлав. ТУЗ хурлын шийдвэрүүдийг компанийн вэбсайт “mglaqua.mn” болон Монголын Хөрөнгийн биржийн”mse.mn” вэбсайтаар тогтмол мэдээлж ажиллав.
- 2025 оны эхний хагас жилд компанийн Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо 2 удаа хуралдаж ТУЗ –д нэр дэвшигчид болон гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийн мэдээллүүдийг хэлэлцэж ТУЗ-д танилцуулав.
- Аудит эрсдлийн хороо тайлант хугацаанд 2 удаа хуралдаж компанийн аудитын хийх байгууллага болон компанийн 2024 оны үйл ажиллагаанд өөрийн дүгнэлтийг өгч ТУЗ-д танилцуулж ажиллав.
- ТУЗ –ийн Хөрөнгө оруулагчдын харилцааны хороо тайлант хугацаанд 1 удаа хуралдаж Хувьцаа эзэмшигчээс ирсэн хүсэлтийг шийдвэрлэв.
- ТУЗ - ийн дэргэдэх Стратеги Бизнес хөгжлийн хороо тайлант хугацаанд 2 удаа хуралдаж Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө болон өөрийн хорооны үйл ажиллагааны журмыг хэлэлцэж ТУЗ-д танилцуулав.
- Тайлант хугацаанд компанийн вэбсайтын “Хөрөнгө оруулагчид” цэсийг хөгжүүлж компанийн болон ТУЗ-ийн  тайлан мэдээллүүдийг тогтмол байршуулж ажиллаж байна.
- 2025.04.23 өдөр компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар “Agm.mn” холбоосоор амжилттай зохион байгуулав. ХЭХ-ийн зөвлөх компаниар Бидисек ҮЦК ХК хамтарч ажиллав.
- Компани 2024 онд IPO хийснээс хойш анх удаа БОНЗ болон Компанийн засаглалын тайлан гаргаж өөрийн вэбсайт болон Монголын Хөрөнгийн Биржийн сайтаар мэдээлэв.
- “Эм Жи Эл Акуа” ХК нь 2024 оны ногдол ашгийн хүрээнд нэгж хувьцаанд 7 төгрөг 31 мөнгө (татварын өмнөх дүнгээр) олгохоор шийдвэрлэсэн бөгөөд ногдол ашгийг 2025 оны 5 дугаар сарын 05-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төв (ҮЦТХТ)-ийн дансанд амжилттай байршууллаа.

# Гүйцэтгэх удирдлагын баг



**С. АЛТАНТУЯА**
Гүйцэтгэх захирал



**Б. БАТ-ОРГИЛ**
Гүйцэтгэх захирлын орлогч



**Б. АРИУНЖАРГАЛ**
БОНЗ дотоод хяналт



**Б. ДАШЗЭВЭГ**
Түгээлтийн албаны дарга



**Ч. ТҮВШИН**
Маркетингийн албаны дарга



**Д. БАТ-ИРЭЭДҮЙ**
Ерөнхий нягтлан бодогч



**Н. МАГСАРЖАВ**
Үйлдвэрийн албаны дарга



**А. НАМУУНАА**
Захиргаа, Хүний нөөцийн мэргэжилтэн



**Г. ГАН-ЭРДЭНЭ**
Борлуулалтын ахлах менежер



**Н. БЯМБАЦЭЦЭГ**
Чанарын менежер

# Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

## 2025 оны эхний хагас жилд

2025
**15,9**
сая литр

2025
**12,1**
сая ширхэг

Савласан цэвэр ус үйлдвэрлэсэн



# Үйлдвэрийн хүчин чадал /хоногт/

| TECH-LONG | KRONES | Sidel |
| --- | --- | --- |
| Future consumption 4.5л | Immediate consumption 330мл, 500мл, 400мл | Future consumption 200мл, 800мл, 1.5л |
| 97,200л үйлдвэрлэнэ | 120,000л үйлдвэрлэнэ | 108,000л үйлдвэрлэнэ |
| 21,600ш савлана | 240,000ш савлана | 72,000ш савлана |



# Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт

**20 тонн**
давхар шатлалт урвуу осмос фильтер суурилуулав

Шүүсэн усны гарц
**2 ДАХИН**
нэмэгдсэн

Хоногт
**480тн**

## Шинэ Компрессор



Хийн компрессорын хүчин чадлыг нэмэгдүүлж, өмнөх 25 MPa даралттай системд 35 MPa хүчин чадал бүхий нэмэлт компрессор суурилуулснаар нийт 60 MPa даралттай болсон.

25MPa
+35MPa
60MPa

# Бүтээгдэхүүн

## Immediate consumption




### 200мл

Олон улсад хэрэглэгддэг Pocket water буюу халаасанд багтахуйц савлагаа бөгөөд усны хаягдал багасгах зорилготой үйлдвэрлэгдсэн. Зорилтот хэрэглээ нь богино хэмжээний хурал уулзалт, эмийн сан, бага насны хүүхдүүдэд зориулагдсан.




### 330мл

Mining, At work, ED, HoReCa сувгийн хэрэглэгчдэд чиглэсэн.




### 500мл

Борлуулалтын бүх сувгууд, бүх насны хэрэглэгчдэд зориулсан, амны цангаа тайлах зохимжит үндсэн савлагаа.




### 800мл

Бүх төрлийн спортоор хичээллэх үед төгс зохицсон хэрэглээ юм.

## Future consumption




### 330мл

Уул уурхай, At work, ED, HORECA, сувгийн хэрэглэгчдэд чиглэсэн.




### 500мл

Тэнцвэртэй хэрэглээнд зориулан байгалийн цэвэршүүлсэн хужраар баяжуулж зөөлрүүлсэн pH 8.5 шүлтлэг ус.




### 1.5л

Орон нутаг, уул уурхай, сувгийн хэрэглэгчдэд зориулсан хэмнэлттэй савлагаа.




### 4.5л

Гэр бүлийн хэрэглээнд зориулагдсан хамгийн том савлагаа. Авч явахад хялбар бариултай, баллонтой ус буцалгагчид суурилуулан ашиглах боломжтой ухаалаг бөглөөтэй.

# Борлуулалтын үзүүлэлтүүд

## Борлуулалтын хэмжээ
Мөнгөн дүн (Тэр бум төгрөг)




## Борлуулалтын хэмжээ
Сая ширхэг




## Нэг харилцагчийн дундаж татан авалтын өсөлт
VPO / Мөнгөн дүнгээр



# Түгээлтийн алба

## Эхний хагас жилийн үзүүлэлт




**89**
Ажилтан

**26** ш
Түгээлтийн машин

**52,313** км
Зам туулж

**55,541**
Харилцагчид бүтээгдэхүүнээ түгээсэн /Давхардсан тоогоор/

**15,887** тн
Савласан усыг харилцагчдад хүргэсэн

# Түгээлтийн алба

## Парк шинэчлэлт

Албан ёсны дистрибьютер болох MSM group компаниас хамтын ажиллагааны хүрээнд **2 жил тутамд** парк шинэчлэлт хийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж байна.

2025.03.20-ны өдөр ачаалал даах чадвартай, аюулгүй ажиллагаатай Mitsubishi брэндийн Fuso маркийн **4,8 тонн даацтай 11 автомашинаар** парк шинэчлэлт хийв.

**1,692,027,207₮-ийн** хөрөнгө оруулалт хийлээ.












# Орон нутгийн борлуулалт

**2024** онд **157**
гэрээтээр дамжуулан

**3709**

**Харилцагч**

**2025** онд **1-6-р сард** шинээр
**8** гэрээт нээж нийт **165**

**4119**

**Харилцагч** +11%



# Дархан салбар

## 6 сарын 3-нд нээгдлээ



**8**
Ажилтан

**2**
Түгээлтийн машин

**160м2**
Агуулах

**410**
Харилцагч

# Ажлын байр бий болголт

67%
Эрэгтэй ажилчдын эзлэх хувь



33%
Эмэгтэй ажилчдын эзлэх хувь

**226**
Компанийн нийт ажилчдын тоо

- 1 ХАБЭА
- 38 Борлуулалт
- 3 Чанар, хяналт
- 3 Маркетинг
- 24 Захиргаа, ХН
- 10 Тусгай хэрэгцээт
- 7 ОН борлуулалт
- 80 Түгээлт
- 3 Тэтгэврийн насны
- 11 Ашиглалт үйлчилгээ хангамж
- 46 Үйлдвэр



# Залгамж халааны бодлого сургалт, хөгжил

**16**
Удаагийн сургалт

**11**
Мэргэжлийн сургалт

**5**
Дотоод сургалт

## Мэргэжлийн сургалт

MLC BUSINESS SCHOOL | Захирлуудын хөтөлбөр CEO COLLEGE

**1012** цаг

## Дотоод сургалт

- Гүйцэтгэлийн үнэлгээний сургалт
- Түгээлтийн албаны ажилтнуудын аюулгүй ажиллагааны сургалт
- Үйлдвэрийн албаны ажилтнуудын аюулгүй ажиллагааны сургалт
- Шинэ ажилтан дасан зохицох сургалт
- Журамын сургалт

**125** цаг




- Мэргэжлийн сургалт
- Дотоод сургалт

# Ханбогд төсөл



**2025.02 сард**
- Газрын зориулалт өөрчлөн, үйлдвэр үйлчилгээний зориулалттай болгосон.

**2025.02 сард**
- Зориулалтын дагуу Ти Эм Эл Акуа ХХК дээр газрын гэрчилгээ авав.
- Үйлдвэрлэлийн зориулалттай худаг хүлээн авсан.

**2025.03 сард**
- Төслийг хэрэгжүүлэх Ерөнхий гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлаж, сонгон шалгаруулалт хийн ТУЗ-аас өгсөн сонирхлын зөрчилтэй гэрээ хийх зөвшөөрөл олгосны дагуу гүйцэтгэгч Ньюгор ХХК-тай гэрээ байгуулсан.

**2025.04 сард**
- 4100м2 Төслийн барилгын бэлтгэл ажил эхлүүлсэн.
- Төлөвлөгөө, төсөв батлагдав.

**2025.05-06 сард**
- Барилга эхлүүлэхтэй холбоотой холбогдох тусгай зөвшөөрлүүдийг авсан.
- Суурийн ажлын явц 80% гүйцэтгэсэн.
- Материалын судалгаа, захиалга хийхэд гүйцэтгэгчтэй хамтран хийсэн.

**2025.06-07 сард**
- Зохиогчийн болон захиалагчийн хяналтын ажлуудыг хийх, төслийн явцад хяналт тавигдана.
- Тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлууд төлөвлөж байна.

**2025.08-09 сард**
- Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлууд эхлүүлэх.
- Тоног төхөөрөмжийн жигдрүүлэх ажлуудыг хийж дуусгахаар төлөвлөж байна.

**2025.10 сард**
- Ти Эм Эл Акуа ХХК-ний 4100м2 үйлдвэр, агуулах, оффисын барилгыг улсын комисст хүлээлгэх өгөхөөр төлөвлөж байна.

# Брэнд маркетинг

**“Тэнцвэртэй өөрийгөө хайрлая”** аяны хүрээнд Voyage брэндээр дамжуулан нийгэмд, сэтгэлзүйн эрүүл мэндийн талаарх зөв ойлголтыг түгээн, эерэг амьдралын хэв маягийг дэмжих олон талт үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Энэ санаачлагыг **салбар салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд** дэмжин, **мэргэжлийн байр сууринаас** үнэтэй хувь нэмэр оруулж, хамтран ажилласан нь аяны агуулга, үр нөлөөг гүнзгийрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.



**Б. Жаргаа -** Коуч, багш Тэнцвэртэй сэтгэлзүй




**Ж. Баатарболд -** Тэнцвэртэй дасгал, хөдөлгөөн




**Т. Цэрэнтогтох /PhD/ -** Хоол боловсруулах эрхтэн судлалын эмч/




**Д. Нямсамбуу –** Гавж, Сэтгэлийн амар амгалан



**1,151,098**

**Нийт хандалт**

# Брэнд маркетинг

"Voyage брэнд нь өөрийн гарал үүсэл болох Бумбатын ариун дагшин рашааны үнэ цэнийг хэрэглэгчдэд таниулах зорилгоор брэнд видео реклам бэлтгэн гүйцэтгэлээ. Уг видео нь байгалийн гүний усны цэвэр ариун чанарыг онцолж, хэрэглэгчдийн итгэлтэй хэрэглээний суурь ойлголтыг бий болгоход чиглэсэн.







MGL aqua

# Хэрэглэгчийг урамшуулах хөтөлбөр /Loyal consumers/

Voyage брэндийн үнэнч хэрэглэгчдээ урамшуулах, цэвэр усны хэрэглээг нэмэгдүүлэх борлуулалтаа дэмжих зорилгоор **“Drink & Win”** хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

DRINK & WIN
УРАМШУУЛАЛТ ХӨТӨЛБӨР

**1,107,298**
**Нийт хандалт**







Хөтөлбөрийн хугацаа
**2025.06.00-2025.07.10**



# Харилцагчийн хамтын ажиллагаа

Voyage брэндийн үнэнч хэрэглэгчдээ урамшуулах, цэвэр усны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор **“Voyage Surprise”** хөтөлбөрийг хэрэгжүүлэв.

**63,634** ⬆ +313.5%

Хэрэглэгч оролцсон

**256,744** Нийт хандалт

Хөтөлбөрийн хугацаа **2025.05.01-2025.06.30**



MGL aqua

# Чанарын хяналт

| Гадаад хяналт | Хими | Микробиологи | Физик |
|---|---|---|---|
|  | 6 Удаагийн шинжилгээ /50 үзүүлэлт/ | 6 Удаагийн шинжилгээ /3 үзүүлэлт/ | 40 Удаагийн шинжилгээ /18 үзүүлэлт/ |
| ЭКО СТАНДАРТ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭКО ЛАБОРАТОРИ | 11 Удаагийн шинжилгээ /45 үзүүлэлт/ | 11 Удаагийн шинжилгээ /3 үзүүлэлт/ |  |
| ГЕОЛОГИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ | 5 Удаагийн шинжилгээ /60 үзүүлэлт/ | 5 Удаагийн шинжилгээ /3 үзүүлэлт/ | 45 Удаагийн шинжилгээ /25 үзүүлэлт/ |
| FOOD ANALYSIS PROFICIENCY TESTING PROGRAM NRL | 3 Удаагийн шинжилгээ /55 үзүүлэлт/ | 3 Удаагийн шинжилгээ /3 үзүүлэлт/ |  |

Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатори

| Дотоод хяналт | Хими | Микробиологи | Физик |
|---|---|---|---|
| MNS 5007:2022 | 815 Удаагийн шинжилгээ /15 үзүүлэлт/ | 115 Удаагийн шинжилгээ /5 үзүүлэлт/ |  |
| MNS900:2018 | 585 Удаагийн шинжилгээ /13 үзүүлэлт/ | 95 Удаагийн шинжилгээ /5 үзүүлэлт/ |  |
| 6648:2016 |  | 145 Удаагийн шинжилгээ /3 үзүүлэлт/ | 312 Удаагийн шинжилгээ /6 үзүүлэлт/ |

Дотоод хяналтын лаборатори

Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатори, дотоод хяналтын лабораториор баталгаажсан олон улсын стандарт шаардлага хангасан савласан цэвэр ус үйлдвэрлэн түгээж байна.

# ГУРАВ.
# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

# Санхүүгийн үзүүлэлтүүд /Хагас жил/

## Борлуулалтын орлого
/Тэр бум төгрөг/




## Цэвэр ашиг /Тэр бум төгрөг/




## Нийт хөрөнгө /Тэр бум төгрөг/




## Эздийн өмч /Тэр бум төгрөг/



# Санхүүгийн үзүүлэлтүүд /Хагас жил/

## Татвар /Сая төгрөг/




## Нийгмийн даатгал /Сая төгрөг/




## Үзүүлэлтүүд

| | |
|---|---|
| ROA | 1% |
| ROE | 1% |
| P/B Харьцаа | 1.2 |
| EPS Харьцаа | 6.3 |
| P/E Харьцаа | 33 |

# IPO - Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

## 1. Ерөнхий мэдээлэл

“Эм Жи Эл Акуа” ХК нь IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ашиглахаар төлөвлөсөн.

2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр нийт 15,234,677,184 (арван таван тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун ная дөрвөн) төгрөгийг IPO-оор амжилттай татан төвлөрүүлж, компанийн банкны дансанд хүлээн авсан болно.

## 2. Хөрөнгийн зарцуулалт

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт дараах байдлаар хийгдсэн байна.

2.1. Түүхий эд, материалын худалдан авалт IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,116,812,809 төгрөгийг түүхий эд, материал (ТЭМ) худалдан авахад зарцуулсан бөгөөд уг зардлыг 2024 онд бүрэн санхүүжүүлж дуусгасан.

2.2. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам худалдан авахад 4,500,000,000 төгрөг, трансформатор худалдан авахад 550,000,000 төгрөг тус тус зарцуулсан (Зураг 1).

# IPO - Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

**Зураг 1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө**




Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эхний багц болох цэвэршүүлэх (филтер) шугамыг 2025 оны 5 дугаар сарын 3-наас 5 дугаар сарын 23-ны хооронд суурилуулсан. Үйлдвэрийн зуны оргил ачааллын үе дууссаны дараагаар үлдсэн тоног төхөөрөмжийг 2025 оны 11 дүгээр сар гэхэд бүрэн суурилуулж дуусгахаар төлөвлөж байна.

## 2.3. Орон нутгийн үйлдвэрийн төсөл

Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр байгуулах төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн.

1. Өмнөговь аймагт газар худалдан авч, Эм жи эл акуа ХК-ийн охин компанийгбайгуулсан.
2. Үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

2025 оны 5 дугаар сарын 29-ний байдлаар орон нутгийн үйлдвэрийн төсөлд IPO-оостатан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6,067,863,875 төгрөг, компанийн өөрийн орлогоос 70,138,125 төгрөг тус тус зарцуулсан байна.

# IPO - Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

### 3. IPO хөрөнгийн зарцуулалттай холбоотой хугацаа хойшлох шалтгаан

Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр барих төсөл нь анхны төлөвлөгөөний дагуу 2025 оны эхний хагаст ашиглалтад орохоор тусгагдсан байсан ч дараах бодит шалтгаануудын улмаас хэрэгжилтийн хугацаа хойшлогдсон. Үүнд:

3.1. Усны нөөцийн хайгуулын хугацаа урт сунжирсан Өмнөговь аймагт усны геофизикийн болон гидрогеологийн хайгуулын судалгаанууд нь олон үе шаттай, цаг хугацаа шаардсан үйл явц бөгөөд зөвшөөрөл олголт, үр дүнг баталгаажуулах ажиллагаа хойшилсон.

3.2. Байгаль орчны үнэлгээтэй холбоотой шаардлагууд Усны хайгуулын дараах байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх үйл явц нь урьдчилан тооцоолсноос удааширсан.

3.3. Зураг төсөл, тендер шалгаруулалтын хугацааҮйлдвэрийн барилга, дэд бүтцийн зураг төслийг батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа цаг хугацаа авч, графикаас хоцорсон.

3.4. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах, зөвшөөрөл авах үе шат удааширсан төсөлтэй холбоотой зөвшөөрөл, дэмжлэгийг орон нутгийн байгууллагуудаас авах явцад тодорхой хугацааны зөрүү гарсан.

Одоогоор төслийн хэрэгжилт шинэчлэгдсэн графикийн дагуу хэвийн үргэлжилжбайна.

# ДӨРӨВ.
# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ

MGL aqua

# Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг “Ногоон санаачилга”

## 1000ш

Гацуур мод тарилаа

АР ЖАНЧИВЛАН




ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Усны ай савыг хамгаалж,байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг “Ногоон санаачилга” төсөл хэрэгжүүллээ.

## 1000ш

Улиас мод тарилаа

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
БУМБАТЫН РАШААН



# Хог хаягдлын менежмент

Хаягдал гялгар
**3.5 тонн**

Хаягдал төмөр
**2 тн 260кг**

Хаягдал хуванцар
**3 тонн**

Ахуйн хог хаягдал
**480 тонн**

Хаягдал пивор
**3.8 тонн**

Хаягдал дугуй
**60ш**

Аюултай хог хаягдал /акуммлятор/
**8ш**

**Ашиглагдах чиглэл:**

Үйлдвэрийн нийт хог хаягдлын 60 хувийг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин ашиглах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж байна.

# Усны менежмент

Эргэлтийн усны системийн бүтээн байгуулалт

Шугам хоолойн урт
**18 метр**

Ус нийлүүлэх өндөр
**3.8 метр**

Нийлүүлэх хүчин чадал цагт
**4 тонн м/с**

**Ашиглагдах чиглэл:**

Олон нийтэд үйлдвэрийн хаягдал ус нийлүүлэх нээлттэй худгийн дэд бүтцийн ажил хийж гүйцэтгэсэн. /: Ногоон байгууламж услах, Машин угаалгын газарт, барилгын шавар зуурах .../

# Нийгэм хандив тусламжийн бодлого




**11 ТӨР БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ААНБ ХАМАРСАН**

Нийт дэмжлэгийн мөнгөн дүн

# 32 САЯ

## Боловсрол спортын дэмжлэг

Сонгинохайрхан дүүргийн спортын хорооны өсвөрийн дугуйн багийг Хүүхдийн спортын VIII наадамд оролцоход нь дэмжин ажиллаа.

## Нийгмийн халамжийн чиглэл

Кристина нобелийн хүүхдийн сан, Нархан гэр хотхон асрамжийн газар хамтран ажиллах санамж бичиг байгууллаа

## Өсвөрийн тамирчдыг дэмжих

JCI Токио, JCI Монгол хамтарсан “Ванпаку сумо” төсөл Монгол оронд 7 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Уг тэмцээнийг дэмжин ажиллаа

# Компанийн засаглал удирдлагын тогтолцоо

## ISO 14001, ISO 45001 стандарт

Урт хугацааны тогтвортой хөгжил, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд ISO 14001, ISO 45001 стандартуудын шаардлагад нийцсэн менежментийн тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлж байна. Энэхүү тогтолцоо нь шийдвэр гаргалт, үйл ажиллагааны бүх шатанд суурилж, хяналт-шинжилгээ, тасралтгүй сайжруулалтад чиглэж байна.







Нэвтрүүлэлтийн явц

**41%**

### Одоогийн байдалд үнэлгээ хийсэн
Эрсдэл, боломж, нийцлийн үнэлгээ

### Стандартын сургалт
Удирдлагын баг, гол ажилтнуудад

### Баримт бичгийн бүтэц төлөвлөгөө
Менежментийн тогтолцооны үндэс

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА